

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймаг
Ханбогд сум

Иргэдийн хөгжлийн төв

2015 оны 12-р сарын 11

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ээлжит хурал 2015 оны 12 дүгээр сарын 11-ний өдөр Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Уулзалтанд Ханбогд сумын Захиргаа, Малчид, ОТ ХХК-ийн төлөөллүүд болон Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газрын (ЭЗХЗОГ) чиглүүлэгч нар оролцов.

Уг уулзалтаар ОТ компанийн төлөөллийн зүгээс Бор овоогийн задгайн өөрчлөлтийн байдлын талаар мэдээлэл өгч, сумын захиргаа болон малчдын төлөөлөлд шинэ Бор овоогийн задгайн тохижуулалтыг танилцуулах аялал зохион байгуулахаар болов. Мөн Ундайн голын гольдролын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээ хийсэн Хөндлөнгийн шинжээчдийн багийн 1-р шатны үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим асуудлыг хэлэлцлээ. Үүний нэг нь Ундайн голын экосистемийн үйлчлэлийн эдийн засгийн үнэлгээг хэрэгжүүлэх тухай 10-р зөвлөмж юм. Уг аргачлалын талаар Талууд хэлэлцсэний эцэст холбогдох судлаачид мэргэжилтнүүдийн саналыг тодруулсны үндсэн дээр дахин хэлэлцэхээр санал тохиров. Үүний дараа 13-р зөвлөмжийн асуудалтай холбогдуулан Ундайн гол дагуу нутагладаг малчин өрхийн санал хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх тухай хэлэлцсэн бөгөөд малчин өрхүүдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл боловсруулахаар санал нэгдлээ.

Энэхүү хурлын өмнөх өдөр буюу 12 сарын 10-ны өдөр ЭЗХЗОГ –аас зохион байгуулсан Зөрчил маргаан шийдвэрлэх чадвар дээшлүүлэх сургалтанд Зөвлөлийн гишүүд хамрагдлаа. Сургалтаар зөрчил маргаан, ашиг сонирхол, төсөөллийг ойлгох, маргааныг шийдвэрлэх арга хэрэгсэл сэдвээр хичээл зааж дадлага хийсэн юм. Уг сургалтыг зохион байгуулсан ЭЗХЗОГ-ын чиглүүлэгч багш нарт Зөвлөлийн гишүүд талархал илэрхийллээ.

Ханбогд сумын Гурван талт зөвлөл

Гурван Талт Зөвлөлийн тухай

Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зүрсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газраас (ЭЗХЗОГ) чиглүүлж байна. ЭЗХЗОГбол Дэлхийн банкны группын Олон улсын санхүүгийн корпорацид чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хараат бус байгууллага болно.